

Ойн тухай хуулийн хэрэгжилтийн талаар хийсэн
хэлэлцүүлгийн илтгэх хуудас

2015.06.30

Аймгийн Хууль хяналтын байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөний шийдвэрийг хэрэгжүүлж “ОЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХАД ОРОН НУТГИЙН ОРОЛЦОО, ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ НЬ” сэдэвт хэлэлцүүлгийг “Ойн судалгаа хөгжлийн төв” Улсын төсөвт үйлдвэрийн газар, аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газартай хамтран зохион байгууллаа.

Уг хэлэлцүүлэгт ойн сан бүхий сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга, хурлын төлөөлөгч, байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч нар болон мэргэжлийн ойн ангийн дарга нар оролцсон бөгөөд Ойн тухай хуулийг хэрэгжүүлэх явцад тулгамдаж байгаа асуудлыг ярилцан хэд хэдэн чиглэлээр шийдэлд хүрлээ. Үүнд:

1.Хуулийн хэрэгжилтийг сайжруулах, хуулийн ойлголт, зохицуулалтуудыг нэг мөр хэрэглэж хэвшүүлэх талаар аймгийн Засаг даргын албан даалгавар гаргах

2.Байгаль хамгаалагч нарыг сумын Засаг даргаас томилдог болох асуудлыг холбогдох дээд газарт санал тавьж шийдвэрлүүлэх,

3.Сумдад үнэт цаас бичих эрх бүхий этгээдийг Мэргэжлийн ойн ангиас томилж, гэрээ байгуулан ажиллах

4.Ойн тухай хууль тогтоомж зөрчиж хууль бус мод бэлтгэсэн, тээвэрлэсэн зөрчил гаргагчийн зөрчил гаргахдаа ашигласан тээврийн хэрэгслийг хурааж улсын орлого болгох шүүхийн практикийг хэрэгжүүлэх

Дээрхи хэлэлцүүлгээр ярилцсан санал, шийдлүүдийг нэгтгэн аймгийн Засаг даргын 01 тоот албан даалгавар гаргаж сум, байгууллагуудад хүргүүлээд байна.

Хууль зүйн хэлтэс

/Албан даалгаварыг эхээр нь оруулах/

Химийн аюултай болон хортой бодисын тухай хуулийн хэрэгжилтийг
аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлээ.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн даргын баталсан удирдамжийн дагуу Булган аймаг дах Тагнуулын хэлтэс, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газрын хамтарсан ажлын хэсэг гарч Тэшиг сумын Тавын алтны уурхайн үйл ажиллагаанд Химийн аюултай болон хортой бодисын тухай хуулийн хэрэгжилтийг, Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамжийн дагуу Булган сумын аж ахуйн нэгжүүдэд уг хуулийн хэрэгжилтийг шалгасан тухай мэдээллийг нэгтгэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэв.

Тэргүүлэгчдийн хуралдаанаас Химийн хортой болон аюултай бодисын хадгалалт хамгаалалт, ашиглалтгүй болсон сав баглаа боодлыг устгах асуудлыг анхаарах, Тавтын алтны уурхайд хадгалагдаж буй хугацаа нь дууссан, ашиглах боломжгүй тэсэрч дэлбэрэх бодисыг устгах арга хэмжээг шуурхай зохион байгуулахыг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад үүрэг болгосон тогтоол гаргалаа.

Хууль зүйн хэлтэс

/тогтоолын бүрэн эхээр нь оруулах /